



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 06 сарын 26 өдөр

Дугаар А/251

Мандалговь

Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Сайнцагаан сумын төвийн 7 дугаар багийн нутаг дэвсгэр (С.Буюннэмэхийн өргөн чөлөө 1-101а тоот)-д байршилтай 700 м.кв (0,07 га) газрыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (9033397)-т нийтийн орон сууцны зориулалтаар 15 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

Хоёр. Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газартай газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгохыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Сайнцагаан сумын Засаг дарга, хотын захирагч (Р.Мөнхтогтох), аймгийн Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

430190700